

“Жуулчин говь” ХК-ийн ТУЗ-ийн

Хурлын тэмдэглэл

2023-04-24

Улаанбаатар хот.

“Жуулчинговь”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04-р сарын 24-ны өдрийн 13 цагт “Монгол савхи” ХК-ийн танхимд хуралдлаа.

Хурлын дарга: Г.Мөнхбилэг: хурлыг нээж нарийн бичгийн дарга ирцийг илтгэ гэв.

НБДарга:С.Батбилэг ирцыг танилцуулав.

“Жуулчинговь”ХК-ийн хувьцааны 67542 ширхэг хувьцааг эзэмшигч 5 хувьцаа эзэмшигч хуралд хүрэлцэн ирж 71,72 хувийн ирцтэй байна.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- ✓ Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан
- ✓ Компанийн ТУЗ-ийн тайлан
- ✓ Аудитын хорооны тайлан
- ✓ ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Г.Мөнхбилэг : Дэгийн дагуу компанийн үйл ажиллагааны дагуу Гүйцэтгэх захирал Б.Гантулга тавина.

Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг Б.Гантулга танилцуулав./Хурлын материалд тайланг хавсаргав.

Хуралд оролцогчид 100 хувийн саналаар тайлангуудаа сонссоны дараа асуулт хариулт явуулахаар боллоо.

Г.Мөнхбилэг: Дэгийн дагуу ТУЗ-ийн 2022 оны тайланг танилцуулав./Хурлын материалд тайланг хавсаргав/.

Г.Мөнхбилэг : Аудитын хорооны тайланг А.Цэцэгдэлгэр танилцуулана гэв.

Аудитын хорооны тайланг А.Цэцэгдэлгэр танилцуулав./ Хурлын материалд тайланг хавсаргав/.

Г.Мөнхбилэг: Санхүүгийн тайланд орлого зарлага зөрүүтэй байна үүнийг яаж шийдсэн бэ.

П.Мөнгөнцэцэг Зээл авч шийдвэрлэсэн өнгөрсөн онд 44 сая 545мянган төгрөгний алдагдалтай ажилласан.

Б.Гантулга: 2022 онд үйл ажиллагаа явуулах боломжгүй байлаа . Санхүүгийн хувьд боломж хязгаарлагдмал байсан ч гэсэн зохих боломж бололцоогоороо баазуудад засвар үйлчилгээ хийсэн. Жил болгон ХЭХуралд жилийн ажлын тайлангаа тавьж үнэлэлт дүгнэлт авч ажиллаж байлаа. Өнгөрсөн жил Жуулчинговь,Хонгор-2 бааз ажиллаагүйгээс санхүүгийн хувьд алдагдалтай жил болж өнгөрсөн. Баазуудын гэр болон объект хуучирсан муудсан байгааг засаж шинэчлэх шаардлагтай байна.

Ч.Тогтохбаяр: Хоёр баазад тооллого хийсэн үү? Эд хогшил ямар байгаа вэ?

П.Мөнгөнцэцэг: Тооллого хийсэн.Үйл ажиллагаа явуулаагүй удаан зогссон учир гэрийн бүрээс, дээвэр туурга бүгд муудсан.

Ж.Энхтунгалаг гэрийн бүрээс нь хулдаас шиг нано бүрээс гарсан байналээ түүнийг сонирхож үзвэл зүгээр санагдсан.

Г.Мөнхбилэг: Баазын үйл ажиллагааг хэвийн ажиллуулахын тулд засвар, шинэчлэл хийх шаардлагатай юм байна. Ж.Энхтунгалаг та хэдэн хувьцаа эзэмшидэг вэ.

1996 онд анх хувьцааг худалдаж авсан ихэнх хувьцаагаа зарсан. Би төмөр замд ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан 1ш хувьцаатай.

А.Цэцэгдэлгэр: Компанийн тайлан баланс дээр ямар нэг асуудал байхгүй. Жил болгон танилцаж дүгнэлт бичиж баталгаажуулж байна. Ноогдол ашиг өгөх боломжгүй гээд ТУЗ-ийн тогтоол гарсан байгаа санал шүүмжлэл дууслаа дэгийн дагуу ТУЗ-ийн нэр дэвшигчийг танилцуулна.

НБДарга: ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нарыг танилцуулав. Д.Ганболд нь цаашид ажиллах боломжгүй гэж чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн. Д.Ганболдын оронд Г.Мөнхбилэг нэрээ дэвшүүлэн орж ирж байгаа.

Г.Мөнхбилэг асуух асуулт байвал асуугаарай.

Д.Мөнхсайхан, Г.Мөнхбилэг гуайг дэмжиж байна.

Хурлын дарга: Тооллогын комисс саналын хуудсаар авсан тооллогын дүнг танилуулна уу.

Тооллогын комиссын дарга: Д.Сүрэнхорол санал хураалгын дүг тооллогын комисс нэгтгэж, тогтоолын төлийг танилцуулав.

1. Саналын хуудсаар компанийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн тайлан, Аудитын хорооны тайланг хувьцаа эзэмшигчид 100хувь зөвшөөрсөн байна.
2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Г.Мөнхбилэг, Д.Хуушаан, Ч.Тогтохбаяр, Д.Мөнхсайхан, А.Цэцэгдэлгэр, Ч.Уранбайгаль, хараат бус гишүүнээр нэр дэвшигч Ж.Одонбаяр, Э.Мөнхсайхан, Ө.Будханд нарт 67,542 ширхэг саналаар буюу 100 хувийн саналаар тус тус авсанг хуралд оролцогчид санал нэгтэй батлав.

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Жуулчинговь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын иогтоолыг танилцуулж баталлаа.

1. Тогтоол №1 Тайлан батлах/2022 оны үйл ажиллагааны тайлан, Аудитын хорооны тайлан, ТУЗ-ийн тайлан
2. Тогтоол 2 ТУЗ-ийн гишүүдийг батлах. Хурлыг 13.55 цагт хаав.

Танилцсан: Хурлын дарга

Тэмдэглэл хөтөлсөн:

Г.Мөнхбилэг

С.Батбилэг

